



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, дансаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Авлигатай тэмцэх газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 7 (долоон) ширхэг суудлын автомашиныг 721,000,000.00 (долоон зуун хорин нэгэн сая) төгрөгт багтаан худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах машины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар 3. Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтанд заасан үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгах, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ




• 132001296

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын

2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн

134 дугаар тогтоолын хавсралт



Авлигатай тэмцэх газрын олж авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын машин, жип, хөдөлгүүрийн багтаамж-3,956 cc суудлын тоо-5	196,000,000.00	1	196,000,000.00
2	Микробус, тусгай тоноглолтой, хөдөлгүүрийн багтаамж-2,359 cc	105,000,000.00	1	105,000,000.00
3	Микробус, энгийн, хөдөлгүүрийн багтаамж-2,359 cc	90,000,000.00	2	180,000,000.00
4	Суудлын машин, хөдөлгүүрийн багтаамж-2000 cc, суудлын тоо-5	80,000,000.00	3	240,000,000.00
5	Дүн		7	721,000,000.00 (долоо зуун хорин нэгэн сая)